

БНХАУ-ААС МОНГОЛ УЛСАД ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ЗУНХУА НИЙГЭМЛЭГИЙН ТЭРГҮҮН ЛЮ ВЕНЬКЕГИЙН ХЭЛСЭН ҮГ

Хүндэт элчин сайг Ван Сяолун!

Хүндэт доктор Шүрхүү!

Эрхэм ноёд хатагтай, та бүхний энэ өглөөний амгаланг айлтгая!

Миний бие Монголд хөрөнгө оруулалттай Шаньдунгийн «Шижир алт» уул уурхайн компаний ерөнхий захирал төдийгүй Монгол улс дахь Хятадын бизнесийн зөвлөлийн тэргүүлэгч хүн билээ. Би өнөөдөр хэлэлцэж байгаа үндсэн сэдэв болох «Хятадын өөрчлөлт шинэчлэлийн гүнзгийрэлт ба Хятад Монголын харилцааны хөгжлийн шинэ боломж» гэсэн асуудлаар өөрийн санаа бодлоо хэлье гэж бодлоо.

Өөрчлөлт шинэчлэлийн бодлого хэрэгжиж ирснээс нааш Хятад улс хөрш зэргэлдээ улс орнуудтайгаа эдийн засаг, соёл, шинжлэх ухаан техник зэрэг салбарын солилцоо хамтын ажиллагааг гүнзгийрүүлж ирсэн. Сүүлийн жилүүдэд Хятад Монгол хоёр орон стратегийн түншлэлийн харилцаа тогтоосноор (дагалдан) солилцоо хамтын ажиллагаа улам бүр өргөжиж, хоёр талын харилцаа өдөр ирэх тусам нягт зузаан болохын зэрэгцээ харилцааны нааштай эерэг төлөв ажиглагдах болов. Саяхан хуралдаж өнгөрсөн 18 дахь удаагийн гуравдугаар бүгд хурал ХКН-ын ТХ-ноос өөрчлөлтийг бүх талаар гүнзгийрүүлэх зарим чухал асуудлын талаархи тогтоолыг баталж, эдийн засаг, соёл, нийгмийн тогтолцооны салбар дахь өөрчлөлт шинэчлэлийг гүнзгийрүүлэхтэй холбогдсон чухал зохицуулалтыг хийхээр шийдсэн нь Хятад улсын улс төр, эдийн засгийн цаашдын хандлагад гүн гүнзгий нөлөө үзүүлэх нь дамжиггүй юм. Тэгвэл энэ удаагийн өөрчлөлт Хятад Монгол хоёр орны эдийн засаг, худалдааны хөгжилд ямархуу боломжуудыг авчирч, хоёр талын харилцаанд ямар нөлөө үзүүлж болох талаар би өөрийн санаа бодлыг та бүхэнтэй хуваалцъя.

ХКН-ын 18 дахь удаагийн гуравдугаар бүгд хурлын

албан мэдээ нь Хятадын шинэ засгийн газрын цаашид хэрэгжүүлэх улс төрийн бодлогын хөтөлбөр юм хэмээн үзэж болохоор байна. Энэхүү хөтөлбөр нь өөрчлөлт шинэчлэлийг гүнзгийрүүлж, илүү гүнзгий асуудлыг шийдвэрлэх явдлыг үндсэн чиг шугам болгож, улс төр, эдийн засаг, соёл, цэрэг, гадаад 55/бодлого зэрэг асуудлын үндсэн зарчмыг бүрэн тодорхой болгож өгсөний зэрэгцээ, эдийн засгийн бүтцийн өөрчлөлт нь өөрчлөлтийг бүх талаар гүнзгийрүүлэх асуудлын амин гол цэг болохыг онцлож байгаа юм. Тэр дундаа засгийн газар болон зах зээлийн харилцааг зохицуулж, баялгийн хуваарилалтад зах зээл шийдвэрлэх үүрэг гүйцэтгэхээр болсны зэрэгцээ засгийн газрын олон нийтэд үйлчлэх үүргийг илүү тодорхой болгосон нь маш гол цөм асуудал болж байна.

Эдийн засгийн даяаршлын шинэ нөхцөл байдалд гадаад дотоодод нээлттэй байх бодлогыг урагшлуулж, харилцан тус дөхөм үзүүлэхийн зэрэгцээ, хөрөнгө оруулалт, хөрөнгийн гадаад урсгалыг улам сайн уялдуулан зохицуулах шаардлагатай. Дотоод гадаадын чухал хүчин зүйлс эмх журамтай чөлөөтэй хөрвөж, баялгийг өндөр үр ашигтай хуваарилан, зах зээлийг гүнзгий нийцүүлэн, олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны шинэ давуу талыг өөрт ашигтайгаар эргүүлж оролцоог хурдасгахын зэрэгцээ, нээлттэй байдлаар өөрчлөлт шинэчлэлд тус дөхөм үзүүлж, хөрөнгө оруулалтын хязгаарлалтыг багасгаж, чөлөөт худалдааны бүсийн бүтээн байгуулалтыг түргэсгэн, нутаг дэвсгэрийн гүнээс хил хязгаар руу чиглэсэн нээлттэй байдлыг өргөжүүлэх болно гэдгийг бүгд хурлаас онцлон заасан.

Хөрш зэргэлдээ улс орнуудтай явуулах гадаад бодлогыг тодорхойлсноор шинэ өөрчлөлтийн давалгаа харьцангуй өндөр түвшинд гадаадад нээлттэй байх, олон улсын өрсөлдөөнд татан оруулах, Хятад улсын дэлхий дахинтай тогтоосон хэлхээ холбоог улам бүр бэхжүүлснээр манай орны дэлхийн хөгжилд эзлэх байр суурь батжиж чадлаа хэмээн 18 дахь удаагийн гуравдугаар бүгд хурлаас мэдэгдэв. Бүгд хурлын албан мэдээ нь дэлхийн энтэй хурц хараа, бүс нутгуудыг багтаасан ухагдахуун, гүн гүнзгий боломж болон наад цаадхийг бодсон ухамсрыг илтгэн харуулахын зэрэгцээ, өөрчлөлтийн шинэ давалгаа дэлхийн нөхцөл байдал лугаа хөл

нийлүүлэн, олон улсын урсгалтай зохицож, гариг дэлхийн хөгжил лүгээ хамт урагшлах учиртайг тодорхой болгож өгөв. Хятад улсын сэргэн мандалын үйл явц нь олон улсын хамтын нийгэмлэгт ойлгомжтой, хүлээн зөвшөөрөгдсөн хэв маягаар хэрэгжих учиртай.

Си Зиньпин ерөнхий нарийн бичгийн дарга 10 сарын 25-ны өдөр хөрш зэргэлдээ улстай хэрэгжүүлэх гадаад бодлогын ажилтнуудын уулзалтанд оролцоходоо: Манай орны өөрчлөлт шинэчлэл, тогтвортой байдалд тааламжтай гадаад орчинг буй болгож, улс орныхоо бүрэн эрх, аюулгүй байдал, хөгжлийн эрх ашгийг сахин хангахын зэрэгцээ даян дэлхийн энх тайван тогтвортой байдлыг хамгаалж, хамтран хөгжихөд тус дөхөм үзүүлэх учиртайг онцолсон билээ.

ХКН-ын 18 дахь удаагийн гуравдугаар бүтд хурлын албан мэдээ болон Си Зиньпин даргын хэлсэн үгнээс үзэхэд улс төрийн тал дээр сайн хөршийн найрсаг байдлыг хэрэгжүүлэн, эдийн засгийн хувьд зах зээлтэй нягт нийцүүлэх нь Хятад улс цаашдаа Хятад Монголын харилцаанд баримтлах үндсэн тулгуур зарчим болохыг ойлгоход бэрх биш юм.

Хоёр орны сайн хөршийн найрсаг харилцаа чухал болох талаар: Одоо олон улсын нөхцөл байдал нарийн төвөгтэй байгаа хэдий ч энх тайван хөгжил түүний гол урсгал чиглэл байсаар байгаа билээ. Монгол улстай сайн хөршийн найрсаг харилцаагаа хөгжүүлэн бэхжүүлж, хил орчмын бүс нутгийн амар түвшин байдлыг сахин хангахын зэрэгцээ, үндэстний бүс нутгийн эв нэгдэл болон хөгжилд тус дөхөм үзүүлэх нь Хятадаас Монголын талаар баримталж байгаа бодлогын гол агуулга төдийгүй, Хятад улсын хөрш зэргэлдээ орнуудтай хэрэгжүүлж байгаа бодлогын чухал бүрэлдэхүүн хэсэг юм.

Монгол бол Хятадын умардын хөрш бөгөөд 4700 км хилийн шугамаар залгагддаг. Түүний зэрэгцээ монгол үндэстэн хоёр орны хил хязгаарыг дамнан амьдардаг болохоор Хятад Монголын харилцааг сайтар хөгжүүлэх нь хичнээн чухал болохыг өгүүлэх юун. Хятад улстай сайн хөршийн найрсаг харилцаагаа хөгжүүлэх явдал Монголын хувьд ч онцгой чухал билээ. Монгол Улсын ерөнхий сайд Н.Алтанхуяг саяхан Хятад улсад айлчлах үедээ: Хятад улсын хэрэгжүүлж байгаа сайн хөршийн найрсаг харилцааны бодлого нь хөрш зэргэлдээ улс

орнуудын хөгжилд тааламжтай нөхцөл байдлыг буй болгож байна гэдгийг онцлон тэмдэглэсэн.

Хятадтай найрсаг харилцаагаа хөгжүүлэх нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиг шугам болохоор хоёр орны стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлж, худалдаа, эрчим хүч, харилцаа холбоо, банк санхүү, хөдөө аж ахуй, хил орчмын бүс нутаг болон хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагааг бэхжүүлэх хүсэл сонирхолтой байгаагаа ч мөн илэрхийлсэн. Харилцан ашигтай байдлыг хангаж, хоёр талын харилцааг урт удаан хугацааны турш , тогтвортой урагшлуулан хөгжүүлснээр сайн хөршийн найрсаг харилцааг сахин хангах нь хоёр орны хувьд оногдож буй хамтын хариуцлага юм. Улс төрийн харилцан итгэлцлийг бэхжүүлж, стратегийн хамтын ажиллагааг өрнүүлэн, хоёр орны язгуур эрх ашгийг хөндсөн чухал асуудлууд дээр, харилцан бие биедээ дэмжлэг үзүүлж, боловсрол, соёлын салбар болон залуучуудын солилцоо хамтын ажиллагааг гүнзгийрүүлснээр, Хятад Монголын харилцааг хөгжүүлэх иргэний санаа бодлын суурийг батжуулж чадах юм. Гагцхүү ингэж чадсанаар хоёр талын харилцаа өнө удаан энх амгалан оршин тогтнох боломжтой.

Хятад Монголын харилцааны шинэ боломжийн талаар: Эдийн засаг худалдааны хамтын ажиллагааг хөгжүүлж, харилцан ашигтай байснаар иргэдээ баяжуулж, улсаа хүчирхэгжүүлэх нь бидний хамтын хүсэл эрмэлзэл билээ. Хятад Монгол хоёр орон нь адилхан хөгжиж байгаа улс төдийгүй эдийн засгаа хөгжүүлж, иргэдийн амьжиргааг сайжруулах чухал үүргийг хүлээж байна. Түүнчлэн манай хоёр орон эдийн засгаа зах зээлийн баримжаагаар хөгжүүлэх чиг шугамыг баримтлан, зах зээлийн эдийн засгийн тогтолцоог байгуулсан билээ.

Эдгээр тогтолцооны дотор хамгийн чухал зарчим нь болвоос зах зээлийн зүй тогтлын дагуу эдийн засгаа харилцан ашигтай байдлаар хөгжүүлэх явдал юм. Засгийн газар нь зах зээлийн дунд гүйцэтгэх үүрэг болвоос зах зээлийн дэг журмыг тогтоон хөгжүүлж, төлөвлөн журамласнаар, зах зээл нь баялгийн хуваарилалтын дунд анхны үүрэгтэй оролцдог байснаа улмаар шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг болохоор

шийдвэрлэсэн нь ХКН-ын 18 дахь удаагийн гуравдугаар бүгд хурлаас тогтоосон өөрчлөлт шинэчлэлийн чухал зорилт юм. Энэ бүхнээс үзэхэд бид манай засгийн газар шат дамжлагыг цөөлөн эрх мэдлийн хуваарилалтыг тарааж, үйлдвэрийн газар худалдааг чөлөөтэй эрхлэх шийдвэр зоригийг өргөжүүлснээр зах зээлийг үр дүнтэй өдөөж, зах зээлийн эрч хүчийг сэргээх болно. Сүүлийн жилүүдэд хятад улсын эдийн засгийн түргэн хурдацтай хөгжлийг дагалдаад асар том хэрэглээний зах зээл бүрэлдэн тогтсон нь бүс нутгийнхаа эдийн засгийг өөд татаад зогсохгүй, дэлхийн эдийн засагт ч чухал нөлөө үзүүлэх болов.

Хятад Монголын эдийн засаг нь харилцан нөхвөрлөх боломж маш сайтай бөгөөд баялгаар жишээ болгон авч үзэхэд уул уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлбэ гэвээс эх газрын улс болох Монголын хувьд зах зээлийн тал дээр хязгаарлагдмал юм. Хятадын түргэн хурдацтай хөгжил нь асар том түүхий эдийн хэрэглээний зах зээлийг бүрэлдүүлсэн бөгөөд энэхүү зах зээлийн харилцаа нь хосгүй болохоор Монгол улс уул уурхайг түшиглэн хөгжих төрийн бодлогод дэмжлэг үзүүлэх болно.

Ялангуяа төмрийн хүдэр, нүүрс зэрэг тээврийн царигийн хязгаарлалтаас хамаарах түүхий эд нь хятадын зах зээлээс хамааралгүй байна гэвэл эдийн засгийн үнэ цэнэ нь ихээхэн хэмжээгээр доошлох төдийгүй үнэгүйдэж мэдэх ч аюултай юм. Монголын түүхий эд баялаг хятадын зах зээлд орж чадсан цагт, зах зээлийн үр ашигтай нөхвөр болох төдийгүй түүхий эдийн зах зээлийг тогтворжуулахад дэмжлэг болох нь тодорхой. Түүний зэрэгцээ хөрөнгө оруулалтын салбарт ч гэсэн Хятад Монгол хоёр орны хооронд хамтын ажиллагааны өргөн орон зай байгаа. Сүүлийн гучин жилийн хөгжлийн явцад одоогийн хятад орон нь дан ганц хөрөнгө татагч орон байхаа больсон төдийгүй дэлхийн гуравдагч том хөрөнгө оруулагч болон хувираад байна. 2012 онд Хятадын гадаад хөрөнгө оруулалтын хэмжээ 84 тэрбум америк долларт хүрчээ. Харин Монголын эдийн засгийн хөгжилтөнд асар их хөрөнгийн хэрэгцээ шаардлага буй бөгөөд энэ салбарт хэрхэн хамтын ажиллагааг өрнүүлэх вэ гэдэг дээр хоёр орны засгийн газар нөхцөл боломжийг буй болгон зах зээлийг бүтээж буй болгох шаардлагатай юм. Хятад улс нь уул уурхайг ашиглах,

замын болон үл хөдлөх хөрөнгийн бүтээн байгуулалт зэрэг тал дээр төлөвшилийг олсон удирдлага болон техникийн чадавхитай төдийгүй, хямд төсөр ажиллах хүчинтэй билээ. Тийм болохоор энэ тал дээр дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвар маш сайтай. Харин Монгол Улс хөгжлийн явцад дээр дурьдсан салбаруудын хэрэгцээ шаардлага бодитой оршиж байгаа бөгөөд холбогдох зах зээлийг буй болгож эрүүл саруулаар хөгжүүлэх нь Монголын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хурдасгах төдийгүй хоёр талын эдийн засаг худалдааны харилцааг эерүүлэн зөөлрүүлэхэд ч маш чухал ач холбогдолтой.

Шинэ нөхцөл байдалд Хятад Монголын эдийн засаг худалдааны хамтын ажиллагааг хэрхэн шинэ өндөрлөгт гаргах вэ гэдэг асуудлын гол зангилаа нь хоёр орны зах зээлийн харилцан зохицон нийцэх чанар юм. Хятад улсын зах зээл бүс нутгийн эдийн засаг худалдааны үйл ажиллагааг хөтлөн дагуулах үүрэг нэгэнт бүрэлдэн буй болоод хөрш зэргэлдээ улсуудын экспортын эдийн засаг үндсэндээ Хятад улсыг хамгийн том зах зээлээ хэмээн үзэх болжээ. Монголын зах зээл нь газар зүйн болон түүхий эд баялгийн давуу талаа зах зээлийн давуу тал болгож чадах аваас Монголын экспортын эдийн засгийн өрсөлдөх чадварыг шийдвэрлэж чадна. Монголын зах зээл нь гадаадаас хараат байдал харьцангуй өндөр болохоор тогтвортой экспортын эдийн засгийг бүрэлдүүлж чадахгүй бол худалдааны тэнцвэрийг хангахад амаргүй. Тийм болохоор экспортын эдийн засаг нь Монголын эдийн засгийг сайжруулах гол зангилаа билээ. Монголд хөрөнгө оруулалттай Хятадын компаниуд нь тус орны эдийн засгийн чухал бүрэлдхүүн хэсэг төдийгүй Монголын экспортын эдийн засгийн зонхилох хүч юм. Дээр дурьдсан компаниудад хөрөнгө, техник, удирдлага байгаа болохоор тэдний хөрөнгө оруулалтын болон бизнесийн орчинг сайжруулж, үр ашигтай үйлдвэрлэл явуулах боломж олгож, шаардлагагүй өртгийг бууруулж чадвал хүчтэй өрсөлдөөн бий болж Монголын экспортын эдийн засгийн өнөөгийн байдлыг түргэн хурдацтай өөрчлөх боломжтой.

Монголд хөрөнгө оруулсан Хятадын компани болохын хувьд бид бүхэн хоёр орны тогтвортой улс төрийн харилцааны

суурин дээр эдийн засаг худалдааны хамтын ажиллагаа өрнөж байгааг харах тааламжтай байдаг. Цаашдаа хятадын эдийн засагт зах зээл шийдвэрлэх үүрэгтэй оролцох болохоор шудрага өрсөлдөх боломжийг олгож байна. Бид ч гэсэн үйлдвэрийн газруудын улс орны эдийн засагт эзлэх байр суурийг дээшлүүлж, хөрөнгө оруулалт, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгосноор олон нийтийн ухамсарт үйлдвэрийн газруудын улсын эдийн засагт оруулж байгаа хувь нэмрийг зөв ойлгуулан, байгальд ээлтэй бизнесийн таатай орчинг буй болгохыг Монголын засгийн газарт уриалж байна. Монголчуудын зах зээлийн эдийн засгийн тухай ойлголт улам бүр дээшлэхийг дагалдан Монгол улсын эдийн засаг улам бүр сайжирч, үйлдвэрийн газрууд ч тэр хэрээр томрон хоёр орны хамтын хөгжилтөнд түлхэц үзүүлэхийн зэрэгцээ хоёр орны харилцааг илүү нягтруулах нь эдийн засгийн болон иргэний ухамсрын бат бөх бааз суурийг тавьж өгнө гэдэгт эргэлзэхгүй байна.

Анхааралт тавьсанд баярлалаа.